



## ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 3 сарын 20 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### Гишүүдэд чиглэл өгөх тухай


Монгол Улсын Ерөнхий Сайдын 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 51 дүгээр захирамжаар батлагдсан “Орчны бохирдлын үндэсний хорооны ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороог Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо болгон өөрчилсүгэй.

2. Орчны бохирдлын үндэсний хорооны 2016-2017 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 11 дүгээр хэсэгт заасан “Зорилтот бүлгийн өрхийг сайжруулсан зуухаар хангах”, 12 дугаар хэсэгт заасан “Зорилтот бүлгийн өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангах” ажлуудыг яаралтай эхлүүлэх, зорилтот бүлгийн судалгаа, тооллого, бэлтгэл ажлыг зохион байгуулах, 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн дотор бүрэн хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдод даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны Нарийн бичгийн дарга Г.Нямдаваа, Ж.Батбаясгалан нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,  
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА



Ж.ЭРДЭНЭБАТ